



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/394

Мөрөн сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны ээлжит XX хуралдааны 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн 2023 оны төсвийн хөрөнгөөр сум, агентлаг байгууллагад эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх хавсралтад заасан арга хэмжээний зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг мэргэжлийн байгууллагаар хянуулан худалдан авах ажиллагааг зохион байгуулж, сонгогдсон гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахыг сумын Засаг дарга, холбогдох төсвийн шууд захирагч нарт тус тус даалгасугай.

3. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр шуурхай зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд байршуулж ажиллахыг сум, агентлаг, байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны 07
дугаар сарын 18-ны өдрийн А/ЗДЧ
дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР СУМ АГЕНТЛАГА, БАЙГУУЛЛАГАД ЭРХ
ШИЛЖҮҮЛЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

2023.07.17

Мөрөн сум

Д/д	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр, нэр төрөл, тоо хэмжээ хүчин чадал	Хугацаа		Төсөвт өртөг (мян.төг)	Тухайн онд санхүүжих дүн (мян.төг)	Төндөр зарлах огноо	Батлагдсан эх үүсвэр	Эрх шилжүүлэн авах сум, байгууллаг ын нэр
		Эхлэх	Дуусах					
2.1.3	Номын сангийн сан хөмрөгийн баяжилт хийх /Нийтийн номын сан/ Хүүхдийн 2-р цэцэрлэгийн нүхэн жорлон /нойл/ барих /Хөвсгөл аймаг, Жаргалант сум/	2023	2023	10,000.0	10,000.0	2023.07.17 2023.10.01	Орон нутгийн хөгжлийн сан	Нийтийн номын сан
2.1.8	Гялаадын намгийн зам засвар арчлалт /Хөвсгөл аймаг, Улаан-Уул сум/	2023	2023	5,000.0	5,000.0	2023.07.17 2023.10.01	Орон нутгийн хөгжлийн сан	Жаргалант сумын ЗДТГ
2.1.9	Цагаан загас үржүүлгийн зөвлөх үйлчилгээ авах /Хөвсгөл аймаг, Цагааннуур сум/	2023	2023	19,000.0	19,000.0	2023.07.17 2023.10.01	Орон нутгийн хөгжлийн сан	Улаан-Уул сумын ЗДТГ
2.1.10	Өл, тоомын давааны зам засвар, арчлалт /Хөвсгөл аймаг, Улаан-Уул сум/	2023	2023	10,000.0	10,000.0	2023.07.17 2023.10.01	Орон нутгийн хөгжлийн сан	БОАЖГазар
2.1.11	Хүрэн булгийн далангийн зам засвар, арчлалт /Хөвсгөл аймаг, Арбулаг сум/	2023	2023	19,000.0	19,000.0	2023.07.17 2023.10.01	Орон нутгийн хөгжлийн сан	Улаан-Уул сумын ЗДТГ
2.1.12	Ерөнхий боловсролын сургуулийн танхимын засвар /Хөвсгөл аймаг, Галт сум/	2023	2023	11,000.0	11,000.0	2023.07.17 2023.10.01	Орон нутгийн хөгжлийн сан	Арбулаг сумын ЗДТГ
2.1.13	Дулааны шугам сүлжээний ажил /Хөвсгөл аймаг, Түнэл сум/	2023	2023	12,000.0	12,000.0	2023.07.17 2023.10.01	Орон нутгийн хөгжлийн сан	Галт сумын ЗДТГ
		2023	2023	15,000.0	15,000.0	2023.07.17 2023.10.01	Орон нутгийн хөгжлийн сан	Түнэл сумын ЗДТГ

2.1.2	Эмт 1-р багийн чиглэлийн зам арчлалт, засварын ажлын дуусгалт /Хөвсгөл аймаг, Баянзүрх сум/	2023	2023	11,000.0	11,000.0	2023.07.17 2023.10.01	Замын сан	Банзүрх сумын ЗДТГ
2.1.4	Сумын төвөөс Үүрийн голын бетонон гүүр хүртэлх 6 км зам засвар /Хөвсгөл, Цагаан-Үүр сум/	2023	2023	16,000.0	16,000.0	2023.07.17 2023.10.01	Замын сан	Цагаан-Үүр сумын ЗДТГ
Зураг төсвийн эрх шилжүүлэх								
2.1.4	Өдөр өнжүүлэх ерөөний тохижилтын засвар /Аймгийн Засаг даргын Тамгын газар/	2023	2023	28,526.6	28,526.6	2023.07.17 2023.10.01	Орон нутгийн хөгжлийн сан	АЗДТГ

оОо